




Боловсролын Инноватив шийдлүүд



Эхний алхмууд

Цахим сурах бичгүүд ба хичээлийн хэрэгслүүд
Сурагчид, багш нарт зориулсан гарын авлага



Бүртгүүлэх

Нэвтрэх

Цахим номууд



M ZAIK

Тойм – Алийг нь юун дээр ашиглах вэ?

Энэхүү гарын авлагыг таны Mozaik-ийн цахим сургалтын хэрэгслүүдтэй танилцах явцыг хөнгөвчлөн, мөн **эхний алхмаа хийхэд тусламж үзүүлэх** зорилгоор бид бэлтгэсэн юм. Цахим сургалтын хэрэгслүүдээ хэрхэн ашиглаж болох, **алийг нь хаана, юунд хэрэглэхийг санал болгож байгаа** талаар харцгаая.



mozaWeb.mn



Веб хөтөч дээр, интернет холболттойгоор ашиглаж болох интерактив веб хуудас.

Цахим номуудаа нээж, интерактив агуулгуудыг нь тоглуулан, сэдэвчилсэн аппуудыг хэрэглэж болно. Шинэ ном, захиалга худалдан авч, онлайнаар гэрийн даалгавараа хийх ч боломжтой.




mozaBook app



Android-той таблет болон гар утсан дээр, iPhone дээр ба iPad дээр үнэ төлбөргүй татан авч болох апп, үүнийг **интернэт холболтгүйгээр ч** ашиглаж болно.

Хаана ч явсан цахим сурах бичгээ авч яван, суулгагдсан интерактив агуулгыг тоглуулж болно. Мөн энэ апп-ыг ашиглан багш нарынхаа эхлүүлсэн интерактив хичээлд нэгдэх боломжтой.




mozaik3D app



Android-той таблет болон гар утсан дээр, iPhone дээр ба iPad дээр үнэ төлбөргүй татан авч болох апп, үүнийг **интернэт холболттойгоор** ашиглаж болно.

Mozaik-ийн бүх 3D үзэгдлүүдийг хичээлийн сэдвээр нь ангилан харж, нээн үзээрэй.



mozaBook




Windows-тэй компьютер ба таблет дээр суулгаж болох үзүүлэнгийн програм, үүнийг **интернэт холболтгүйгээр ч** ашиглаж болно.

Хичээлдээ зориулан үзүүлэн, сургалтын интерактив агуулга үүсгэх, цахим ном нээх, интерактив агуулгыг тоглуулах, сэдэвчилсэн апп-уудыг ашиглах боломжтой.

1. Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх

mozaWeb хуудсыг нээхэд интернэт холболт болон вэб хөтөч шаардлагатай. Хамгийн сайн чанараар харахын тулд Chrome хөтчийг хэрэглэхийг бид санал болгож байна. Хэрэглэгчийн бүртгэл мөн бас байх хэрэгтэй. Хэрвээ бүртгэл байхгүй бол эхний алхамд нэгийг үүсгээрэй! Үүний тулд дараах алхмуудыг дагаад хийгээрэй!

- Вэб хөтөчдөө www.mozaweb.mn хаягийг бичиж оруулаарай **1**.
- **Нэвтрэх** икон дээр даран **2**, нэвтрэх орно уу эсвэл **Шинэ бүртгэл** үүсгэх сонголтыг сонгоорой **3**.



- Нээгдсэн маягыг бөглөөд **4**, сургуулиа бас сонгоорой **5**, учир нь ингэснээрээ ангийнхантайгаа, бас багш нартайгаа бас холбогдох боломжтой болно.
- Хэрвээ чи 16 нас хүрээгүй бол, эцэг эхийн зөвшөөрөл бас хэрэгтэй болно **6**.
- Мэдээлэл нууцлалын мэдэгдлийг уншин хүлээж аваад бүртгэлээ үүсгээрэй **7**.

Анхаарна уу!


Манай систем таны өгсөн имэйл хаягруу захиа илгээх болно, үүнээс хойш 5 хоногийн дотор уг имэйлд байгаа холбоос дээр даран **бүртгэлээ идэвхжүүлэх** шаардлагатай. Хэрвээ идэвхжүүлээгүй бол 5 хоногийн дараа таны бүртгэл автоматаар устгагдах болно.

Амжилттай бүртгүүлсний дараа бид таныг автоматаар нэвтрүүлэх болно, үүгээр ажлаа шууд эхэлж ч болно гэсэн үг. Үүсгэсэн бүртгэлээрээ mozaBook програмд, mozaBook апп-д болон mozaik3D апп-д ч бас нэвтрэн орох боломжтой гэдгийг мэдэхэд илүүдэхгүй.

2. Нэвтрэн орох

Цаашдаа идэвхжүүлэлтийн имэйлд илгээсэн хэрэглэгчийн нэр болон бүртгэлээ үүсгэхдээ өгсөн нууц үгээрээ **хаанаас ч хамаагүй, интернэтэд холбогдсон ямар ч хамаагүй компьютерээс mozaWeb-д нэвтрэн орох боломжтой.**

- Вэб хөтөчдөө **www.mozaWeb.mn** хаягийг бичиж оруулаарай **1**.
- **Нэвтрэх** икон дээр дараад **2**, хэрэглэгчийн нэр болон нууц үгээ өгөн нэвтрэх ороорой **3**.



Зөвлөмж:

Нэвтрэхийн тулд хэрэглэгчийн нэрийнхээ оронд имэйл хаягаа бас хэрэглэж болно.

3. mozaWeb дээр юу хийж болох вэ

mozaWeb хэрэглэгчийн хувьд та дараах зүйлсийг хийх боломжтой:

- **цахим сурах бичиг** худалдаж авах, идэвхжүүлэх болон хайх, мөн эдгээрт агуулагдах нэмэлт агуулгыг тоглуулах.
- **Медиа сангийн зүйлсийг (3D үзэгдлүүд, видео, интерактив дасгалууд, цахим хичээлүүд гэх мэт.)** тоглуулах.
- **олон олон сэдэвчилсэн апп-уудаар (хэрэгслүүд болон тоглоомууд)** хичээл хийхийг тоглоом болгон хувиргах.
- **өөрийн суралцах платформ** үүсгэх, эндээ агуулгуудаа синхрончилж, хуваалцаж болно.
- **багш нарынхаа олгосон онлайн гэрийн даалгаврыг** хийх.
- **багшийн эхлүүлсэн ангийн ажилд** нэгдэх.
- **захиалгууд, лицензүүд болон хэрэглэгчийн өгөдлөө** удирдах.


Үнэ төлбөргүй хэрэглэгчийн бүртгэлтэй тохиолдолд эдгээр боломжууд нь хязгаарлагдмал байдаг, гэхдээ **Mozaik TEACHER** юмуу **Mozaik STUDENT** захиалга худалдан авснаар бүрэн ба хязгааргүй хандах эрхтэй болох болно.



4. Цахим сурах бичгүүд

Нэвтэрсний дараа та бэлэн байгаа цахим номуудыг нээж, тэдгээрт агуулагдсан интерактив агуулгыг тоглуулах боломжтой. Та цахим номууддаа mozaWeb-ээс гадна өөрийн хэрэглэгчийн бүртгэлээр нэвтэрсэн үедээ mozaBook дээр болон mozaBook мобайл апп дээр ч бас хандах боломжтой.

- Та номуудаа Миний цүнх цэсэнд **Миний номууд** хэсэгт олох болно **1**.
- Жагсаалтаас хайж байсан номоо сонгоод хавтсан дээр нь даран нээгээрэй **2**.





Миний хайж байгаа ном жагсаалтад байхгүй бол яах вэ?

Хэрвээ аль нэг ном жагсаалтад байхгүй бол та тэр номонд хандах боломжгүй гэсэн үг. Шинэ цахим номыг вебшопоос худалдан авч болно **3** эсвэл хэрэв танд цахим ном идэвхжүүлэх хүчинтэй код байгаа бол (сургууль дээр өгсөн, эсвэл танд байгаа хэвлэмэл номонд ийм код байсан), энэ кодоороо нийтлэлийг идэвхжүүлэх боломжтой **4**. Идэвхжүүлэх гэдэг нь номыг хэрэглэгчийн бүртгэлтэйгээ холбох гэсэн үг.

Хэрдээ зөв код оруулсан бол систем нь гарч ирэх цонхонд номын талаархи мэдээллийг харуулах ба аль бүртгэлд уг номыг оноох талаар ч бас мэдэгдэх болно.

- Хэрвээ уг мэдээллүүд нь үнэн зөв байвал **Идэвхжүүлэх товч дээр дарна уу** **5**.
- Амжилттай идэвхжүүлсэн номоо **Миний цүнх цэсэн дотор Миний номнууд хэсгээс олох болно** **1**.




Хэрвээ та цахим номоо манай вэб дэлгүүрээс худалдан авсан ба тэр дор нь өөрийн бүртгэлдээ оноосон бол номоо идэвхжүүлэх шаардлагагүй, уг цахим номыг Миний цүнх > Миний номнууд цэснээс олох болно. Хэрвээ номоо худалдан авахдаа бүртгэлдээ оноогоогүй бол, номын идэвхжүүлэх кодыг **Миний худалдан авалт** хэсэгт, баруун дээд буланд байгаа нэрэн дээрээ даран гаргаж ирэх боломжтой **6**.

mozaBook-ийн Android болон iOS системд зориулсан хувилбарыг үнэ төлбөргүйгээр ухаалаг төхөөрөмжрүүгээ (таблет болон ухаалаг утас) татан авч болно. Уг апп нь **цахим сурах бичгүүдээ, мөн эдгээрт агуулагдсан интерактив нэмэлтүүдийг өөртөө аван хаашаа ч хамаагүй явж, интернэт холболтгүйгээр ч ашиглах** боломжийг олгодог. Хэрвээ танай багш интерактив ангийн ажил эхлүүлбэл, уг ажилд апп-аараа нэгдэх боломжтой.

1. Татаж авах, суулгах

- Play Store (Android)-ийг, эсвэл App Store (Apple iOS)-ийг өөрийн ухаалаг утас эсвэл таблет дээрээ нээгээд **mozaBook** гэж хайлтын талбарт бичээд, дараа нь Суулгах дээр дараарай.



Android



Apple iOS



mozabook





mozaBook

Mozaik Education

Суулгах

2. Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх, нэвтрэх

- Анхны удаа нээхэд нэвтрэх дэлгэц гарч ирэх болно. Хэрвээ хэрэглэгчийн бүртгэл аль хэдийн байгаа бол хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулан нэвтрээрэй **1**. Хэрвээ бүртгэл байхгүй бол **Шинэ бүртгэл үүсгэх**-ийг сонгоод бүртгэл үүсгэж болно **2**.



- Хийх алхмуудыг даган, шаардагдах мэдээллийг оруулаарай.
- Хэрвээ чи 16 нас хүрээгүй бол эцэг эхийн зөвшөөрөл бас шаардлагатай.
- Мэдээллийн нууцлалын бодлогыг уншин хүлээж аваад, шинэ бүртгэлээ үүсгээрэй.

Анхаарна уу!

Шинэ бүртгэлээ үүсгэсний дараа автоматаар нэвтрүүлэх ба шууд ажлаа эхлүүлэх боломжтой болно.

Апп-ыг дараа нь нээх үед автоматаар нэвтрүүлэн оруулах болно.

3. Цахим сурах бичгүүдийг татаж авах

- Хандаж болох нийтлэлүүдийг доош гүйлгээж болох жагсаалтад оруулсан байгаа **1**.
- Жагсаалтаас номоо олоогүй бол хайх талбарыг ашиглаарай **2**.
- Та уг номд хандах эрхтэй бол шууд татаж авч болно **3**. Өөрөөр тохируулаагүй бол таны төхөөрөмжид зөвхөн ном татагдах ба үүнийг интернэтгүйгээр ч ашиглаж болно. Номонд агуулагдсан интерактив нэмэлтүүд татагдахгүй ба тэдгээрийг зөвхөн онлайн интернэт холболттойгоор нээж үзэх боломжтой.
- Хэрвээ бүх интерактив агуулга бас таны төхөөрөмж дээр татагдан, офлайн (интернэт холболтгүйгээр) ашиглаж ч бас болохоор байлгахыг хүсч байгаа бол татаж авахдаа нэмэлт агуулгын хамт татаж авах сонголтыг сонгоорой **4**.

Татаж авах

Дараах номыг татаж авах болно:
Mathematics 6.

Татаж авах 25,9 MB

Нэмэлтүүдтэй татаж авах: 116,2 MB

Цуцлах



- Татаж авсан номоо хавтас дээр нь даран нээж, хуудсыг нь скроллоор эргүүлээрэй. Интерактив агуулгуудыг хуудасны зах дээр байгаа жижиг икон дээр даран нээж болно.


4. Номоо идэвхжүүлэх (шаардлагатай бол)

Хэрвээ та аль нэг номонд хандах эрхгүй бол зөвхөн демо хувилбарыг нь ашиглах боломжтой **1**. Бүрэн хэмжээгээр хандахад идэвхжүүлэх код шаардагдана. Хэрвээ танд ийм код байгаа бол уг кодоороо хамаарах номыг идэвхжүүлэх буюу өөрийн хэрэглэгчийн бүртгэлдээ оноох боломжтой.

- Ном идэвхжүүлэх дээр дараарай **2**.
- Нээгдсэн цонхон дахь талбарт идэвхжүүлэх кодыг оруулан, **3** илгээх икон дээр дараарай **4**.

Анхаарна уу!


Хэрэглэгчийн бүртгэлдээ нэвтрэн орсон бол идэвхжүүлсэн цахим номууддаа mozaWeb дээрээс ч хандаж болно.



А mozaik3D апп-ыг Android болон iOS ухаалаг төхөөрөмжрүүгээ (таблет болон ухаалаг утас) үнэ төлбөргүйгээр татаж авч болно. Уг апп нь **3D үзэгдлүүдийг гар утас юмуу таблетээрээ ашиглах** боломжийг олгодог.

1. Татаж авах, суулгах

- Play Store (Android)-ийг, эсвэл App Store (Apple iOS)-ийг өөрийн ухаалаг утас эсвэл таблет дээрээ нээгээд **mozaik3D** гэж хайлтын талбарт бичээд, дараа нь Суулгах дээр дараарай.



Android



Apple iOS



mozaik3D app

Mozaik Education

Суулгах

2. Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх, нэвтрэх



Хэрвээ үнэ төлбөргүй бүртгэл үүсгэсэн бол үнэ төлбөргүй үзэж болох агуулгуудын хажуугаар долоо хоног бүр 5 ширхэг дурын сонгосон 3D үзэгдлийг нээж үзэх боломжтой. Хэрвээ та Mozaik TEACHER юмуу Mozaik STUDENT захиалгатай бол бүх үзэгдлийг чөлөөтэй үзэх боломжтой.



- Апп-ын нүүр хуудсан дээрхи Хэрэглэгч икон дээр дараарай **1**.
- Хэрвээ танд хэрэглэгчийн бүртгэл аль хэдийн байгаа бол хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулан нэвтрээрэй **2**.

- Хэрвээ хэрэглэгчийн бүртгэл байхгүй бол **Шинэ бүртгэл үүсгэх** дээр даран апп дээр ч үүсгэх боломжтой **3**.


- Хийх алхмуудыг даган, шаардагдах мэдээллийг оруулаарай.
- Хэрвээ чи 16 нас хүрээгүй бол эцэг эхийн зөвшөөрөл бас шаардлагатай!
- Нууцлалын бодлогыг уншиж, хүлээн зөвшөөрч, бүртгэлээ үүсгээрэй.



Windows-тэй компьютер дээр юмуу таблет дээр үнэ төлбөргүй суулгах боломжтой mozaBook програм нь **цахим сурах бичгүүддээ хэзээ ч, хаанаас ч хандах боломжийг олгох ба**, эдгээр сурах бичгүүдийг офлайн ч хэрэглэж болно. mozaWeb хуудсын нэгэн адилаар **энд ч бас Медиа сангийн агуулгад болон сэдэвчилсэн апп-уудад хандах боломжтой.**

1. Татаж авах, суулгах

- Програмыг www.mozaweb.mn хуудсанд нэвтрэн ороод татаж авч болно. Хэрвээ хэрэглэгчийн бүртгэл байхгүй бол „mozaWeb – Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх” бүлэгт заасны дагуу үүсгэх боломжтой.
- Шон ❶ цэснээс **mozaBook** хэсгийг сонгоорой ❷.



Анхаарна уу!

Туршилтын хугацааны дараа програмын бүх функцийг ашиглахын тулд дараах захиалгуудын аль нэг шаардлагатай болно:

- mozaBook CLASSROOM
- Mozaik TEACHER
- Mozaik STUDENT

Эдгээр захиалгууд нь хичээл дээрхи ангийн ажилд нэгдэхэд, мөн интерактив гэрийн даалгаварыг хийх боломж олгох болно.

- Гарч ирэх хуудсан дээр 'mozaBook татаж авах'-ыг сонгоорой ❸.
- Бүрэн хэмжээний суулгагчийг сонгон ❹, суулгагч програмыг татаж аваарай ❺.

Сургалтын програмууд



mozaBook

Хэрэглэгчийн лиценз-ийн тусламжтайгаар төрөл бүрийн таблет, гар утас) дээр **mozaBook болон mozaWeb-ийг** ашиглах эсвэл Mozaik платформд хэд хэдэн төхөөрөмжөөр нэвтрэхийг...

Төхөөрөмжид суурилсан лиценз-ийн тусламжтайгаар нэг ашиглах боломжтой болно. Хэрвээ ангийн интерактив самб хэрэглээнд, хэд хэдэн багш, сурагчид ашиглах бол энэ лиценз...



mozaBook татаж авах
Windows-д зориулсан mozaBook

Хэрэглэгчийн гарын авлага | Видео | mozaBook

Татаж авах



mozaBook

Багш нарт зориулсан интерактив сургалтын програм хангамж

Та mozaBook сургалтын үзүүлэлт програм хангамжийг татаж авах түүний санал болгож буй боломжуудыг харуулсан видеог үзээрэй

Хэрэглэгчийн гарын авлага | Видео | mozaBook

Суурилуулалтын төрлийг сонгоно уу: (mozaBook 2024.1.105)

- ☒ Бүрэн хэмжээний суулгагч 1955 MB
- ☐ Багасгасан хэмжээтэй суулгагч 632 MB

Суулгагчийг сонгоно уу:

- ☒ 64 битийн хувилбар
- ☐ 32 битийн хувилбар

Сервэрээ сонгоно уу:

- ☒ Төв Европын сервер (ойролцоогоор. 1 минут)
- ☐ Баруун Европын сервер (ойролцоогоор. 1 минут)
- ☐ Хойд Америкийн сервер (ойролцоогоор. 1 минут)

Татаж авах

- Татаж авсан суулгагч програмыг эхлүүлэн, суулгах заавруудыг дагана уу.
- Суулгах явцад суулгагч нь ширээн дээр икон байрлуулах болно, дараа нь тэр иконоор програмаа нээж болно.

2. Анхны удаа эхлүүлэх

Хэрэв танд хэрэглэгчийн бүртгэл байгаа бол нэвтэрч ороорой **1**. Хэрвээ бүртгэл хараахан байхгүй бол **Шинэ бүртгэл үүсгэх**-ийг сонгоорой **2**.

Нэвтэрч ороход mozaBook нь таны бүртгэлд програмыг бүрэн хэмжээтэйгээр ашиглах боломж олгох лиценз холбогдсон байгаа эсэхийг (ж нь. Mozaik TEACHER эсвэл Mozaik STUDENT лиценз) шалгаж үзэх болно.

- **Хэрэв танд тохирох лиценз байгаа бол** зөвхөн дотоод хэрэглэгчээ л үүсгээд програмыг ашиглах боломжтой. (3-р алхам: Дотоод хэрэглэгчийн бүртгэл)
- **Хэрэв танд хэрэглэгчийн лиценз байхгүй бол:**

DEMO

Програмын бүх функцийг демо горимоор, 30 хоногийн турш туршиж үзэх боломжтой.




Хэрэглэгчийн лицензийг, эсвэл mozaBook-ийн төхөөрөмжид суурилсан лицензийг худалдаж авах боломжтой.



Үргэлжлүүлэн нэвтрэн орж, програмыг хязгаарласан горимд ашиглаж болно.



Хэрэв байгаа бол mozaBook лиценз кодоо оруулж болно.



Хязгаарласан горим:

mozaBook апп-ын нэг адилаар цахим ном болон дасгалын дэвтрүүдээ нэмэлт агуулгын хамтаар нээж болно, гэхдээ та эдгээрийг өөрчилж, хадгалж чадахгүй болно.

3. Дотоод хэрэглэгч

Хэрэглэгчийн бүртгэлээ тохируулсны дараа нэг **дотоод хэрэглэгч** үүсгэх хэрэгтэй.

Уг дотоод хэрэглэгч нь mozaBook-од нэвтрэн ороход хэрэгтэй. Хэд хэдэн дотоод хэрэглэгч ч үүсгэх боломжтой, гэхдээ тэдгээрийг зөвхөн энэ компьютер дээр ашиглаж болно.

- Дурын нууц үгээ оруулаарай **6**.
- Аватараа сонгоорой **7**.
- Ашиглах нөхцлийг уншаад хүлээж аван дотоод хэрэглэгчээ үүсгээрэй **8**!




4. Нэвтрэх

- Дараагийн удаа програмыг эхлүүлэхдээ **аватар дээрээ даран 1**, **нууц үгээ өгөхөд 2** л хангалттай.
- Нэвтэрч орсныхоо дараа юу эхэлж хиймээр байгаагаа сонгоорой: **3**
 - Ном нээх. эсвэл шинэ ном идэвхжүүлж болно.
 - Шинэ, хоосон үзүүлэн үүсгэж болно.
 - Хамгийн сүүлд ажиллаж байсан төлөвийг ачаалж, тэндээсээ үргэлжлүүлж болно.
- Хэрэв та програмыг демо горимд ашиглаж байгаа бол демо хугацаанаас хэдэн хоног үлдсэнийг тоолуур дээр харуулдаг **4**.



5. Цахим сурах бичгүүдийг татаж авах болон нээх

- Хандаж болох номуудыг нийтлэл сонгогчийн доод талын гүйлгээж болох жагсаалтанд **1**, дараах тэмдэглэгээтэйгээр олж болно:
 - Бэлэглэсэн ном, тэр дор нь нээх боломжтой
 - Хандаж болно, татаж авах боломжтой
 - Хандаж болно, нээх боломжтой
 - Хандах боломжгүй, идэвхжүүлэх шаардлагатай
- Хайсан номоо олоогүй бол хайх талбарыг ашиглаарай **2**.




- Номын **онлайн** юмуу **оффлайн** хувилбарыг **татаж авах** боломжтой **3**. Номын аль аль хувилбарыг интернэтгүйгээр нээж болно. Онлайн хувилбарын хувьд номонд байгаа интерактив агуулгыг зөвхөн интернэт холболттойгоор ашиглаж болно гэсэн үг.
- Татаж авсан номоо номын хавтсан дээр даран нээж болно **4**.

6. Шинэ цахим ном худалдаж авах, идэвхжүүлэх

Хэрэв аль нэг номонд хандах эрх байхгүй бол та зөвхөн демо хувилбарыг нь ашиглах боломжтой **1**. Шинэ цахим номыг вебшопоос худалдан авч болно **2** эсвэл хэрэв танд цахим ном идэвхжүүлэх хүчинтэй код байгаа бол (сургууль дээр өгсөн, эсвэл танд байгаа хэвлэмэл номонд ийм код байсан), энэ кодоороо нийтлэлийг идэвхжүүлэх боломжтой **3**.

- Демо хувилбарыг нээхэд номын зөвхөн хэдэн хуудсыг л нээж болдог.
- Хэрэв та манай вебшопоос шинэ ном худалдаж авсан бол уг номоо тэр дор нь бүртгэлтэйгээ холбох боломжтой, тусд нь идэвхжүүлэх шаардлагагүй.
- Худалдаж авахдаа бүртгэлтэйгээ холбоогүй бол номоо идэвхжүүлэх хэрэгтэй. Нээгдэн гарч ирэх цонхон дахь талбарт идэвхжүүлэх кодоо бичиж оруулаад **4**, идэвхжүүлэх икон дээр дараарай **5**.



Шинэ код идэвхжүүлэх

Цахим сурах бичгийн, эсвэл сурах бичгийн багцын идэвхжүүлэх кодыг оруулна уу. Хэрэв та манай вэб дэлгүүрээс худалдан авсан бол бид танд кодыг имэйлээр илгээсэн байгаа.

MOZ – BC – HGXJ – JIEE – CTKS – RXKP – DLKX – 2306EN

5

Идэвхжүүлэх

Худалдан авах

Боловсгоцны код

4

Анхаарна уу!

Хэрэв та өөрийн хэрэглэгчийн бүртгэлээр нэвтэрсэн бол mozaWeb болон mozaBook апп-аас ч идэвхжүүлсэн цахим номнууддаа хандах боломжтой гэдгийг анхаарна уу.

Цаашдын тусламжийг эндээс авч болно:

- Цахим сургалтын хэрэгслүүдийн бидний өөрийн, суурилуулсан тусламжууд
- Mozaik-ын танилцуулгын видеонууд: www.mozaweb.com/solutions
- Mozaik-ын албан ёсны YouTube суваг: www.youtube.com/MozaikEducation
- mozaBook Getting Started гарын авлага: www.mozaweb.com/usermanuals
- mozaWeb Түгээмэл асуудаг асуултууд: www.mozaweb.com/help

